

рэгт хөөгдөн амь наана там цаана зугатаж явсан тул тээврийн хэрэгсэл төдий л хөгжөөгүй тэр үед их говийг гатлан газрын баялаг ашиглах байтугай амь зулбах замдаа тохиолдсон ард иргэдийг алж хядаж өнгөрсөн.

Учир иймд манай эх орны ашигт малтмалаас хятад өөрийн дураар авч ашиглаж байсан нь асар их биш бөгөөд монголчууд тэгж дуранд нь тавьж байгаа ч үгүй, харин болор зэргийг сангийн яам нийслэл дэх монгол, хятад зэрэг ядуу хүмүүсийг хөлслөн авч ухуулан гаргасан болор зэрэг чулуугаа нийслэл хүрэн дэх чулуу эрдэнийн пүүсэнд худалдан, тэр пүүс худалдаж авсныгаа урагшаа тээдэг байсан юм. Манай эх оронд байдаг хэдэн зуун зэсийн ордыг аль эрт цагт Азийн төвөөр амьдарч байсан монгол, кидан, түрэг, уйгар зэрэг олон овог аймгийн хүмүүс хүрэл зэвсгийн үеэс зэс, цайр, тугалга тэргүүтэй ашигт малтмалаар хүрэл зэвсгээ хийж амьдарч ирсэн баялаг түүхтэй билээ.

**ЧИНГИС ХААН ТЭМҮҮЖИНИЙ МЭНДЭЛСНИЙ  
800 ЖИЛИЙН ОЙД ЗОРИУЛАН БОСГОСОН ГЭРЭЛТ  
ХӨШӨӨГ ХҮЛЭЭН АВАХААР ЯВСАН ЗАМЫН ТЭМДЭГЛЭЛ**

**Н. Ишжамц**

Энэ 1962 оны 2-р сарын 14-ний өдөр МАХН-ын Төв Хорооны Улс төрийн Товчооноос Монголын тулгар төрийг үндэслэн байгуулагч Чингис хаан Тэмүжиний мэндэлсний 800 жилийн ойг тэмдэглэж өнгөрүүлэх тухай тогтоол гарсан билээ.

Шинжлэх ухааны Академийн Түүхийн хүрээлэн 1962 оны 5-р сарын 31-ний өдөр Чингисийн төрсний 800 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний бага хурал хийв.

Мөн тэр үеэр Хэнтий аймгийн Дадал сумын нутаг Гурван нуурын амралтын дэргэд Чингисийн хөшөө сүндэрлэн босч байв. Удалгүй уг хөшөө бэлэн болж Шинжлэх ухааны академи хүлээн авах асуудал гарав.

1962 оны 6-р сарын 26-ны өдөр Академийн тэргүүлэгчийн хурал болж оны эхний хагасын ажлын дүн хэлэлцэж байгаад завсарлах зуур Академийн ерөнхийлөгч Б. Ширэндэвээс намайг Чингисийн хөшөө хүлээн авах ажилд томилсон тухай мэдэгдлээ. Мөн асуудлын талаар Академийн дэд ерөнхийлөгч Б. Дашжамц Түүхийн хүрээлэнгийн захирал Ш. Нацагдорж нар намайг дуудаж ярилцан зохих заавар өгөв.

27-ны өдөр явах замын маршрут гаргаж батлуулах зэрэг бэлтгэл ажил хийв. 28-нд Барилгын яаман дээр очиж, Чингисийн хөшөө барих ажлыг удирдсан залуу мэргэжилтэн Чойжамцтай уулзлаа. Энэ хөвгүүн надтай хамт Гурван нуур явж уг хөшөөг хүлээлгэн өгөхөөр

томилогдсон байна. Чингисийн хөшөөг Чойжамц бид хоёр хүлээж авалцах болов. Үдээс хойш болон оройдоо бэлтгэл ажлыг дуусгаад өглөө эртхэн гарахаар шийдлээ. Би хүрээлэн дээгүүрээ очиж нөхөдтэйгөө уулзаад гарлаа. Зарим нь байсангүй, гадагш явсан байв. Гагцхүү Ч. Балжинням гаднаас орж ирж яваатай шатан дээр уулзаж салахын ёс гүйцэтгээд гарч одов. Гэртээ ирвэл аав бас ирээд байлаа. Аав уг нь Хэнтий аймаг, Дадал сум, Гурван нуурын түүгээр олон явсан, газар сайн мэдэх хүн. Мөн тэнд их дэлгэрсэн Чингисийн холбогдолтой яриа дурсгал зэргийг мэдэх тул нэлээд зүйл хэлүүлж авлаа. Ялангуяа Гурван нуураас өртөө шахам зайтай орших Хөхчү бөөгийн агуйг заавал очиж үзвэл зохино, эрдэм шинжилгээний ажил эрхэлсэн хүмүүсээс түүнийг үзсэн хүн бараг байхгүй байх гэнэ. Хөхчү гэдэг бол Чингисийн тахин шүтэж байсан нөлөө бүхий нэгэн их бөө байжээ. Гэвч сүүлдээ Чингистэй эрх булаалдан зөрж байгаад түүнд алагдсан юм. Түүний орогнож байсан агуй үнэхээр тэр мөн бол маш сонирхолтой дурсгалын зүйл мөн байхсан.

5-р сарын 29-ний өглөөний 8 цагт жолооч Дашцэрэнгийн ГАЗ-69 дээр сууж барилгын газрын мэргэжилтэн Чойжамц, Багшийн сургуулийн окутан Осормаа нарын хамт хотоос гарч зүүн өмнө зүг чиглэн хөдлөв. Удалгүй Богд уулын зүүн урд суганд хүрч ирэв. Тэнд Одоо Хонхорын станц гэдэг радио нэвтрүүлгийн төв байдаг байна. Урьдын цагт тэр хавьд түүхийн сонин явдлууд болж байсан газар бололтой. Хонхорын станцын баруун талд мод, устай хоёр сайхан ам харагдана. Ажиглавал Богд уулын хамгийн зүүн өмнө талын алс байна. Гэтэл Магсар хурцын бичсэн Монголын наадмын тухай зохиолд XVII зууны эцсээр Ойрадын Галдан хаан Халхад довтлон орж, өндөр гэгээн, Түшээт хан нар манжийн хил рүү зугатан очоод дагаар орсон бөгөөд хожим манж нар Галданг дараад Халхын ноёдыг нутагт нь буцаахад Өндөр гэгээн, Түшээт хан нар тэргүүтэй олон ноёд Богд уулын зүүн урд талын аманд бууж их баяр ёслол хийсэн, тэгэхдээ лам хувраг, хутагт хувилгаад нь нэг аманд, ноёд тайж нар нь зэргэлдээх аманд тус тус буусан бөгөөд тэр цагаас эхлэн хуврагуудын буусан амы нь Шажин хурахын ам, ноёд тайж нарын буусан амыг Төр хурахын ам гэдэг болсон гэсэн байдаг. Халхын ноёд тийнхүү Шажин хурах, Төр хурахын аманд бууж нутаг усандаа эсэн мэнд буцаж ирсэний баяр наадам хийхэд Богдын Бонхор донир гэгчийн ганц хурдан морь уралдаанд түрүүснээс Түмний эхи гэдэг дуу сэдэгдэн гарсан гэдэг. Нэлээд яваад Зуун мод гэдэг газарт хүрч ирэв. Замын урд талд намхан уулын ар дээр элсэн дээр хэсэг ногоон мод байна. Түүнийг Зуун мод гэдэг юм байжээ. Замын хойт талд эгц босоо улаан шаргал асга бүхий сүртэй нэгэн их хадан уул харагдана. Тэр уулыг ажиглавал мөн түүхэнд нэр гарсан Тооно уул мөн шиг санагдав. 1696 онд манжийн Энх-Амгалан хаан Ойрадын Галдан бошигот хааны цэргийг Тэрэлжийн Зуун мод гэдэг газарт цохиод ялалтаа тэмдэглэн Тооно уулын орой дээр гэрэлт хөшөө босгосон гэдэг. Үнэхээр, Энх-Амгалан хааны босгосон Тооно уулын гэрэлт хөшөөг манайхан олж аваад Улсын төв музейд тавьсан байдаг. Одоо энэ Зуун мод, Тооно уулын түүгээр гарахад өнгөрсөн үеийн түүхийн элдэв сонин явдал сэтгэлд аяндаа дүрслэгдэн ургаж үзэгдэнэ.

Үдийн алдад Хэрлэнгийн буудал дээр хүрч ирэв. Энэ буудал Хэрлэн голын хойт талд нэгэн улаан шаргал хадан хясааны зүүн урд энгэрт байна. Асар томгүй, хэдэн модон байшин, хэсэг гэрээс бүрджээ. Бид зочид буудалд нь орж цай чануулж уув. Тэр зуур хойт хадан хясааны энгэр дээр гарч үзвэл нэг дугаргий булш, хоёр, гурван дөрвөлжин булш байхыг үзэв. Тэд цөм буудлын гуанзны хажууд байна. Дугаргий булш нь гуанзны баруун хаалганы чиг арав гаруй метрийн цаана байна. Дөрвөлжин булшууд нь гуанзны баруухан хойно үзэгдэнэ. Эртний үеийн хүүр оршуулсан газар одоо замын буудал, зочид буудал байгуулагдаж булшны зэрэг гуанз баригдсан нь сонин.

Хэрлэнгийн буудлын баруун өмнө талд нэгэн их огцом хар хадан хясааны байгаагийн өмнө урд доогуур Хэрлэн гол баруун зүг урсан гарчээ. Буудлын зүүн өмнө Хэрлэнгийн модон гүүр байдаг байна. Бид тэр гүүрээр гараад голын урд захад бууж нүүр гараа угааж сэрүүцэв. Өдөр халуун тул сэрүүцэх сайхан байсан боловч Хамаг Монголын хамгийн түүхт голын нэгийг нүдээр үзэж, ариун тунгалаг усанд анх удаа хүрч ирэхэд улам сайхан санагднам. Хэрлэн гол энэ хэсэгтээ маш намуухан урсдаг бөгөөд толь шиг тунгалаг, ус нь зөөлнийг хэлбэл нүүр угаахад тостой гараар илбэж байгаа мэт байх бөгөөд гар нүүр ер нь усаар угаасан биш тосоор тосолсон адил зөөлөн булбарай болно.

Хэрлэнгээс цааш үргэлж олон уул, толгодын хөндий өгсөн уруудан явав. Хажуу хавиргаас уул толгой хашаад алсын бараа үл харагдана. Бидний дунд газар сайн мэдэх хүнгүй учир ямар нэртэй газраар явааг мэдэхэд бэрх байв.

Оройхон тийшээ Хэнтийн наад талын Чандган талд оров. Чандган тал хэдий дорнод Монгол, Авга Сөнөдийн зах хязгаар нь үл үзэгдэх талуудын адил арвин уудам биш боловч ялангуяа урдаасаа хойшоо их явуулдаг болтой. Бид баруунаас зүүн тийш хамгийн нарийн газраар ЗИС-69-ийн хурдыг нэмэгдүүлэн давхисаар зүсэн гарахад мөн нэлээд удаан явуулж байна.

Чандган талыг өнгөрээд бас ууланд оров. Харанхуй болсон тул газрын байдал үл мэдэгдэнэ. Цаг гаруй явсаны дараа алсад олон гэрэл харагдсан нь Хэнтий аймгийн төв Өндөрхаан хот байжээ. Өндөр хан дээр хүрч ирэхэд 23 цаг өнгөрч байв. Хөгжим нижигнэж нийтийн бүжиг наадаж байгаа чимээ сонсогдож байв. Бид зочид буудалд нь очвол сул ор алга. Тэнгэр сайхан байсан учир хээр гарч хонохоор шийдэв. Машинаа асааж аваад хотын хойт талд очиж өвсөн дээр унтацгаав. Шөнө сайхан унтжээ. Гагцхүү үүрээр жаахан даарч өглөө эрт сэрэв.

Ажиглавал бид хотын хойно гараад хүүр оршуулдаг газрынх нь баруухантай унтсан байна. Хотоос гараад хүүрийн газар хонох шахжээ гэж инээдэм болцгоов.

Нар хөөрч ирмэгц Өндөрхааны бензиний клонк дээр очиж бензин авах болов. Жолооч 50 литр бензин авна гэнэ. Клонкийн хүн хотын тээврийн товчооны цохолтгүй бол өгөхгүй гэв. Жолооч маань хотын төв ороод буцаж ирэхэд бензин хүрэхгүй гэж учирлан гуйсанд өгөх болов, Бензинийг урт бүдүүн хоолойгоор машины том лаазанд хийсээр байтал гэнэт бялхаж асгав. Бензиний хүн 10 литр бензин насоод-

чихсон учир багтахгүй болж бялхан гарчээ. Жолооч сандарч нэг том банк гарган тосон нь харин бараг дүүрэн бензинтэй, бас бялхан асгарч эхлэв. Чойжамц бензиний хоолойн цоргыг барьж байсан боловч хааж чадалгүй асгалуулж байв. Осормаа хажууд нь ихэд сандран инээдмийн юм хэлж байв. Хамгийн сонин нь манай жолооч анхандаа бензингүй гэж байснаа дараахан нь дүүрэн савтай бензин гаргаж ирсэн явдал байв. Бид «хулгай муухай баригдав» гэж, хот орох замдаа бөөн инээдэм болов.

Өндөрхаан хот Хэрлэн Цагаан талбай гэдэг нэгэн сайхан тал дунд байна. Ой мод үгүй боловч өвс ус нь жигд нутаг юм. Хотод хуучин шинэ, том жижиг олон барилга байх нь харагдана. Хуучин барилгын дотроос Хэнтий аймгийн орон нутаг судлах хэлтсийн шашны музейг дурдаж болно. Музейд бөөгийн хэнгэрэг, хувцас хунар болон шарын шашны холбогдолтой зүйлсийг нэлээд сайн бүрдүүлж тавьжээ. Төвд, Монгол ном судар бас бузгай цуглуулж чадсан байна. Орон нутаг судлах хэлтсийн харьяа бас нэг музей байна. Тэр нь тэндэхийн гол музей бололтой. Аймгийн хэмжээний ургамал, амьтан, түүх, соёл урлагийн дурсгал болон тус аймгийн эдүгээ цагийн эдийн засаг, соёлын хөгжлийг харуулах үзмэр олныг тавьжээ. Гагцхүү нийт Хэнтий аймаг, ялангуяа Чингисийн төрсөн нутаг Дадал сумын хэмжээнд энд тэндгүй элбэг дэлбэг байдаг эртний Монголын түүх болон Чингисийн үйл амьдралтай холбогдолтой газар, булш хөшөө, агуй чулууны зэрэг олон сонин зүйлийг бүртгэн зураг хөргийг авч хадгалсангүй. Бас Монголын түүх, Чингис хааны холбогдолтой домог яриануудыг цуглуулсангүй байна. Тийм учир бид энэ талын асуудлыг анхаарч байхыг орон нутаг судлах хэлтэс, аймгийн нам захиргааны удирдлагад хүсэлт болгон тавив. Тэд цөм зүйтэй гэж хүлээн аваад зохих хүмүүст анхааруулан хэлж байв.

Бид анх аймгийн намын хорооны даргыг орлож байгаа нөхөр Цэрэннадмидтай уулзаж, хөшөө хүлээж авахаар яваа тухайгаа мэдэгдэн Академийн захидал бичгийг гардуулсан билээ. Дараа нь аймгийн захиргааны дарга Адъяатай уулзаж удтал ярилцав. Энэ хүн түүх бузгай мэддэг. Чингисийн асуудлыг ихэд сонирхон үздэг бөгөөд ер нэлээд тодорхой ойлголттой болсон юм. Чингисийн хөшөөг нээхэд өөрөө хүрэлцэн очихоор шийдэж байв.

6-р сарын 30-ны өдрийн 12 цаг хагаст бид Хэнтий дээрээс гарч Дадалын зүг чиглэн одов, зам нь шавартай учир явахад хүнд байв. Нэг газар манай ГАЗ-69 намагт сууж төмөр аргамжаар татуулж байж арай чарай гарав. Замд үхэр, адуун сүрэг олон тааралдаж байв. Адуу нь сайхан бөгөөд бусад төрлийн малаас олон харагдана. Зуур замд сум нэгдэл, сангийн аж ахуй, уул уурхайн үйлдвэрийн зэрэг суурин газрууд нэлээд тохиолдов. Бид хуучин байсан Цэнхэр мандлын уурхайн дэргэдүүр гарч эдүгээ ажиллаж байгаа Бэрхийн уурхайг дайраад Норовлин дээр ирсэн билээ. Улаанбаатараас гараад Норовлин ортол явахад манай орны хөдөө нутагт суурьшлын байдал нэмэгдэж соёлын довтолгоон шуурхай явагдаж байгаа нь ил байна.

Зам муу, цаг орой болсон тул бид Норовлин сумын зочид буудалд хоноод явах болов. Эндэхийн зочид буудал сүрхий тохилог бөгөөд бас гуанзтай нэг дор байгаа нь хүн амрахад тун тохиромжтой юм. Бид бууз хийлгэж идэн шил архи хувааж уув. Жолооч маань шарлаад эдгэснээс хойш хэдхэн сар болсон тул их уусангүй, Чой-

жамц, Осормаа бид гурав уув. Өмнө шөнө нь хөдөө дутуу нойртой унтсан, өдөр нь туж замд явсан тул архи балгасны дараа бид цөм маш сайхан нойрсон унтжээ. Өглөө босоход бие сайхан амарсан байв.

7-р сарын 1-ний өглөө Норовлингоос гарч хойш одов. Цаг шахам явсны дараа Ононгийн сав газрын уул нурууд харагдав. Модтой шовх хар уулс байх бөгөөд хэлбэр дүрс нь янз бүр, ажиглах ойртох бүр улам сонин санагдана. Удалгүй Онон гол дээр хүрэлцэн очив. Голыг пирваазаар гатлав. Цаад эрэг дээр гараад би морь унаж байж зургаа авахуулав. Байгалийн байдал энд их гоёмсог үзэгдэнэ. Эргэн тойрон бургас шугуй, өнгө бүрийн цэцэг, эндөр хадан хясаа бүхий домогт уулс-энэ бүхэн нь Чингисийн төрсөн нутгийн хавьцаа газар мөн гэж бодоход нэн сонин.

Нутгийн хүмүүсийн ихэнх нь буриад нар байна. Тэд их яриа улс бололтой. Чингисийн хөшөө хүлээж авахаар явааг сонсоод олон зүйлийг сонирхон асууж мөн өөрсдөө сонин юм ярьж байна. Хөшөөг үзсэн заримын сэтгэлд хөшөөний дүрс хэлбэр, бичиг агуулга сайн таарчээ. Гагцхүү Чингисийн биеийг хятаддуу маягтай болчихож гэж шүүмжлэн ярилцаж байна. Монгол хүний зурсан, монгол морь унаж, хуяг дуулга өмсөн сэлэм зүүж, нум агссан баатар эрийн дүрээр хийсэн бол сайнсан гэж байгаа хүмүүс ч үзэгдэнэ. Эд нөхдийн яриа бидний сэтгэлийг татаж, Гурван нуурын зүг улам яаруулав.

10 цагийн үеэр бид Дадал суман дээр хүрэлцэн очиж Осормаагид бууж цай уугаад намын үүр, нэгдлийн захиргааны дарга нартай уулзахаар гарав. Сумын хариуцлагатай нөхөдтэй уулзаж ярилцсаны дараа Гурван нуурын амралт орохоор одов. Гурван нуур дээр хүрч очвол амралтын байр нь Дэлүүн болдог гэдэг нэгэн толгойн энгэрт байгаа өргөн дэвсгэ дээр байна. Өмнө талд нь сайхан нуур байх бөгөөд дундаа жижиг аралтай. Энэ нуурыг Чингисийн Гурван нуурын дунд нуур гэдэг ажээ. Нөгөө хоёр нь дунд нуурын баруун, зүүн талд тусгай оршино.

Дунд нуурын хойт талд эргээс нэлээд зайтай газар тэнгэр хатгасан өндөр шовх оройтой, сүрлэг том цагаан гэрэлт хөшөө үзэгдэх нь бидний хүлээн авах Чингисийн хөшөө мөн байжээ.

Бид шууд явж хөшөөний дэргэд очвол зураач Махбал нэгэн хүний хамт зогсоно. Тэр хүн амралтын дарга Осор гуай гэнэ. Биднийг угтаж аваад Махбалын байгаа зочид буудалд буулгав. Буудал нь дотроо цэнхэр алаг хээтэй бүтээлгээр бүтээсэн нарийн төмөр ортой юм. Дэрийг орны толгойд хажуугаар босгон тавиад мөн орны толгой дээгүүр хөндлөн тохсон шив шинээхэн гадаад алчуурын унжсан талаар хагас халхалжээ. Ор бүрийн хажууд нэг шүүгээ байна. Тасалгааны голд торгомсог шар бүтээлэгтэй жижигхэн дугуй ширээг матмал сандалаар тойруулан тавьсан юм. Хананд хувцасны өлгүүр, радио байна. Цонхонд торон хөшиг унжуулан татсан нь өрөөний заслалыг улам аятай болгожээ.

Бид Махбал, Осор гуай хоёртой ярьж байгаад амралтын үдийн хоолонд оров. Гуанзны тохилог болон хоолны амттай сайн, үйлчилгээний боловсон зэргийг ажиглавал нийслэлийн зарим гуанз атаархмаар ажээ.

Гурван нуурын амралт бол уул ус, өвс ногоо жигдэрсэн сайхан газар юм. Сибирь ба Европын адил ой мод, навч цэцэг энд байна.

Улаан, цагаан, цэнхэр, шар, ягаан өнгийн цэцэг энд тэндгүй алаглан анхилам сайхан үнэр нь байнга үнэртэн бие, сэтгэлийг сэргээнэ. Ялангуяа дунд нуурын байдал үзэсгэлэнтэй бөгөөд амралтын гол чимэг болжээ. Нуурын тойронд бараг ямар ч чимэглэл төхөөрөмж үгүй, гагцхүү хүйс арал болон хойт эрэг дээр хэдэн задгай, будмал модон асар буй. Харин 5-р сард Чингисийн хөшөөг нуурын хойт талд босгосон явдал байдлыг нэн сүрлэг сайхан болгожээ. Намуун өдөр Чингисийн хөшөөний сүүдэр дүр усанд туссаныг нуурын өмнө эрэг дээрээс харахад сонин байдаг байна. Гэвч хөшөөний дэргэд зохих чимэг зэрэг үгүй учир хөшөө ганцаардмал болсон байдал илэрхий.

Чингисийн хөшөөг барихдаа 2 м зузаан чулуун суурь газарт хийж мөн чулуу, цементийн зуурмагаар барьжээ. Гадна талыг нь жонш цементийн зуурмагаар зузаан шавж өнгөлжээ. Нүүрэн тал нь хавтгай, Чингисийн хөргийг зурж сийлсэн, хөргийн баруун мөрөн дээгүүр нэлээд алст гурван сэрээт цагаан сүлд нь сүндэрлэн мандаж байгаагаар зуран сийлж хийжээ. Хөргийн зүүн талд «Алд бие минь алжааваас алжаатугай, Ахуу төр минь бүү алдартугай» гэсэн Чингисийн хэлсэн үгийг хуучин уйгуржин монгол үсгээр сийлж алтан өнгөт боронзоор буджээ. Хөшөөний ар талд Чингисийн 800 жилийн ойд зориулан энэ хөшөөг 1962 оны 5-р сарын 31-нд босгов гэсэн утгатай үгсийг мөн хуучин монголоор сийлжээ.

Үдээс хойш бид баруун нуур очив. Дунд нуураас жижиг, мэдрэлд сайн рашаан гэж алдаршсан юм. Захаас нь арваад метр дотогш ороод гар нүүр, биеийг угааж сэрүүцэв.

Оройн хоолны дараа амралтын үдэшлэгт оров. Танц бүжиг, тоглоом наадам болж байв. Би харж суув. Бүжиг тоглоомын алинд ч оролцсонгүй. Гэвч нэг мэдвэл эмэгтэйчүүдийн вальс явж намайг нэгэн цэвэрхэн өндөр охин урив. Арга буюу босч вальс хийв. Охин гуалиг цэвэрхэн боловч над нэлээд өндөрджээ. Бүжиг тарсан хойно тасагтаа ирвэл Махбал тэр бүсгүйг гуанзны үйлчлэгч, хамгийн сайхан хүүхэн нь мөн, өөрөө над «атаархаж» байна гэнэ. Амралтын нөхөд намайг танц хийхгүй болохоор зориуд тэр хүүхнээрээ уриулсан бололтой.

7-р сарын 2-ны өдөр бид Дадал сумын төвийн баруун хойтох Баян овоон дээр гарч үзэв. Дадал сум Гурван нуурын баруун, баруун хойт талд орших учир Баян овоо бас Онон (Гурван нуур)-ийн амралтаас баруун хойш оршино. Баян овоо нэлээд том бөгөөд ой модоор бүрхэгдсэн уул юм. Орой дээр нь жинхэнэ Баян овоо гэгч нь байна. Тэр овоог чулуу овоолон босгожээ. Хэмжээ нь нэлээд их, орой дээр өндөр мод хатгаж хадаг яндар, номны хуудас, тахилын цөгц, цаг мөнгө зэргийг тавьжээ. Мөн урьд энгэр дээр нь нэгэн хонины толгой байна.

Ардын аман ярианд урьд Чингис хаан аян дайнд явахдаа тэр уулын оройд гарч тугаа тахиад явдаг байсан гэдэг юм байна. Чингисийг үхсэний дараа туг нь тэнд олон үе дамжин тахигдсаар ирсэн гэнэ. Гагцхүү манж, автономитийн үед шарын шашны лам нар Чингисийн тугийн оронд Жанцанхорло гэдэг тугийг шинээр хийж хатган тахих болсон гэнэ. Чингисийн өөрийнх нь тугийг яачихаад тэгэх болоо вэ гэхэд мэдэх хүн алга. Бид овооны хавийг шүүрдэж үзвэл 1924 оныг хүртэл тахиж байсан гүлмэн төмөр жанцангийн суулга нь нэ

гэн ширхэг гал сэрээний үзүүрийн хамт олдов. Мөн иш нь болох үжирч өмхөрсөн гурван бүдүүн мод овооны зүүн хажууд харагдана. Овоог жил бүрийн зуны дунд сарын 13-ны өдөр 60 хонины толгойгоор тахидаг байсан юм байна. Угтамын хувилгаан (Довчин хувилгаан) гэгч хүн эрхэлж тахидаг байсан гэнэ.

Дараа нь Баян овоо уулын хойт талд Тэнгэлэг горхины чанад орших «Доа сохрын хөшөө» гэгчийг очиж үзэв. Замдаа Тэнгэлэг голыг гатлав. Нутгийн ардууд түүнийг Нууц товчооны Түнхлэг горхи мөн гэнэ. Үергүй цагт явган буюу машинаар гаталж болох жижигхэн горхи байна. Тэнд бид нүүр гараа угааж зураг хөрөг авч байгаад цааш явав. Удалгүй «Доа сохрын хөшөөний» дэргэд хүрэлцэн очив. Доа сохрын хөшөө гэдэг нэгэн том дөрвөлжин булшны зүүн урд өнцөгт босгосон хавтгай өндөр чулууг хэлжээ. Тэр хавьд арав гаруй дөрвөлжин булш байхыг үзлээ. Гол төлөв хүрэл зэвсгийн үеийнх байлтай. Гэтэл хамгийн том булшийг чухамхүү Доа сохрын нэртэй холбож ярьсаар ирсэн нь сонин. Тэнд арай Доа сохрын булш үнэхээр байгаа юм биш байгаа гэдэг асуудал гарч ирнэ. Хэрэв тэр булш хүрлийн үеийнх биш, түрэгийн үеийнх буюу эсхүл арай сүүл үеийн бол тийм ч байхад болохгүй гэх газаргүй.

Үдийн хоол идсэний дараа Көгз (хөхчү) бөөгийн агуй гэгчийг үзэхээр явав. Гурван нуурын амралтаас зүүн урагш 15—18 км орчимд байдаг юм байна. Онон голын хойно нэгэн их улаан шар хадан асга бүхий сүрлэг уул байна. Орой дээрээ баруун урагш орсон хөндлөн их хадан нурууны доод үзүүрт алсаас нэгэн гурвалжин нүх харагдаж буй тэр нь уг агуй юм байжээ. Агуй баруун хойт талд маш том бөгөөд эгц ханан хад байна. Агуйд очихын тулд хоёр уулын хоорондуур орсон хөндийг өгсөн, хойш нэлээд явах хэрэгтэй байв. Тэр хөндийн өвс ногоо их, бүсэлхийгээр татам өндөр ажээ. Бороотой цагт горхи урсдаг жалга байна. Бидний явахад төмсний ягаан цэцэг, хонхон улаан цэцэг, цэнийн цагаан цэцэг, бас шар, цэнхэр янз бүрийн цэцэг эрээлжлэн жигдрээд туйлын үзэсгэлэнтэй байв. Өвс ногоо, навч цэцгийн үнэр гойд сайхан анхилж байв. Агуй бүхий уулын ёроолд хүрээд дээш авирах тутам өвс ногоо бага болсоор дан хад асга болно. Хад асгыг гулсан барин авирсаар агуйд нэлээд ойртож очвол авирах зам улам бэрх болно. Ахи ахисаар агуйн амсар үүдэнд хүрэлцэн очивч дав даруй дотор нь орж үл болно. Агуйн амсар бидний зогсож байгаа газраас 2 м дээр үзэгдэнэ. Бид асаж авиран байж арай чарай гарч очоод дотор нь орж үзэв. Дотроо дөрвөн ханатай жижиг гэрийн чинээ зайтай, гонзгой бөмбөгөр хэлбэртэй юм. Хадан хана нь хааяа нурж эвдэрч байдаг бололтой харагдана. Ар мухарт цааш орсон нэлээд урт нүх буй. Гэвч чүдэнз асааж харвал мухар нь харагдаж байна. Өөр тийм салбар нүх хөндий үл үзэгдэнэ. Агуйн хана туурга нь их хөө болжээ. Нутгийн өвгөн Номгон Дорж гуайгаас сонсвол тэнд баахан ном байгаад шатсан юм гэнэ. Уг нь Чингисийн Көгз бөө гэгч их алдар хүчтэй арш бөө байсан бөгөөд хувьсгалын үед Хуриган Бат гэдэг лам орогнож байсан гэж ярьцгаана.

Агуйн үүднээс доош харвал онгоцоор нисч яваа мэт санагдана. Урд доогуур нь Цээнэтийн гол гарна. Баруун урдуур Онон гол үзэсгэлэнтэй сайхан урсч байгаа нь мушгиралдан цэнхэртэж үзэгдэнэ. Онон, Цээнэт голын хөндийд бургас мод, өвс ногоо хослон жигдэр-

чээ. Алс өмнө зүгт нь алдарт Бүрэнхан уул тэргүүтэй ногоон мод бүрхмэл өндөр их уулс сүндэрлэн харагдана. Энэ нутгийн байгалийн үзэсгэлэнг чухам эндээс тодорхой харж болно.

Бид агуйд гарч очих болон дорогш буухад ихээхэн ядарсан боловч амарсан мэт бие сэтгэл сэргэж буцсан билээ. Уулын бэлд буугаад цөм цэцэг түүж дуу дуулж байсан хүүрнэлдэж явлаа.

Энэ агуйд надтай цуг зураач Махбал очсон бөгөөд гар зураг зурж авсан. Мөн инженер Чойжамц, жолооч Дашцэрэн, Ононгийн Ойдов гуай нар явсан. Жич агуйд ороод бид өөрийн авч явсан Туул голынхоо уснаас цацаж, үлдмэрийг тэнд тавьж орхисон. Мөн нэр сэлтээ цаасан дээр бичиж агуйн хананы нэг жижиг нүхэнд хийгээд чулуугаар дарж орхисон буй.

7-р сарын 3-ны өглөөний 10 цагт Чингисийн хөшөөг нээх болов. Хэнтий аймгийн дарга Адъяа хөшөө нээх ажлыг эрхлэн гүйцэтгэхээр хүрэлцэн иржээ. Хөшөөний урд талаар хоёр залуу нарс хатгаж хоорондуур урт улаан бүч татаад өмнө нь өндөрлөг дугуй тавцан зассан байв. 9 цаг хагасын үеэс эхлэн хөшөөний зүг тал бүрээс хөгжин залуу, эрэгтэй эмэгтэй, хүүхэд багачууд олон хүн цугларан ирсээр 10 цаг өнгөрөхөд хөшөөний өмнө талд туг далбаа барьсан пионер, өнгө бүрийн цэцэг барьсан хүмүүс дугуйлан асар том амьд цэцгийн баглаа мэт гоёмсог цагираг болон зогсож байв. Хүн бүхний сэтгэл ихэд хөдлөн баяр баясгалантай байхыг харахад ямар ч баяр ёслолын үеэс илүү гэмээр байлаа. Удалгүй аймгийн дарга Адъяа биднийг дагуулан олны дундуур орж тавцангийн дээр гарав. Дадал сум, Хөдөлмөр нэгдлийн дарга, намын хорооны дарга нар болон Онон амралтын дарга Осор, Барилгын яамны төлөөлөгч Чойжамц, бид нар араар зогсов. Өмнө нь хэсэг пионер том дугаргий улаан тавиур дээр хайч тавьж барин зогсоно. Адъяа гуай хөшөө нээх ёслолын цуглаан нээснийг мэдэгдэж Чингис хааны үйл амьдрал, түүхэн ролийн тухай үг хэлж хөшөөний учир утгыг товч тайлбарлан хэлэв. Чингис хаан Монголын тулгар төрийг үндэслэн байгуулж Монгол аймгуудаа нэгтгэн өвгийн байгууллаас феодалын нийгэмд дэвшин орох хэрэгт идэвхтэй зүтгэн их гавьяа байгуулсан дэвшилтэт үүрэг гүйцэтгэсэн төрийн зүтгэлтэн, гарамгай зохион байгуулагч их жанжин мөн, гэвч харь орныг байлдан эзэлж байсан явдлыг бид харгис явдал гэж үзэх ёстой гэнэ. Хөшөөн дээр Чингисийн дүрсийг сийлэхдээ одоо олдлоод байгаа хамгийн эртний зургийг баримталсан бөгөөд дэргэд нь гурван сэрээтэй цагаан сүлдийг Монголын төр улс байгуулсны тэмдэг болгон сийлсэн юм. «Алд бие минь алжааваас алжаатугай, ахуу төр минь бүү алжаатугай» гэж хуучин монголоор сийлсэн үг бол Чингисийн хэлж, баримталж байсан зүйл мөн гэв. Адъяа гуайг үг хэлж дуусмагц цугларагсад нижигнэтэл алга тавив. Адъяа гуай хайч авч улаан бүчийг хайчлан хөшөөг нээв. Дараа нь олон пионер хөшөөнд амьд цэцэг тавив. Улаанбаатар, Хэнтий, Дорнод аймаг болон бусад байгууллагын хамт олноос бас амьд цэцгийн баглаа тавив. Цугларагсдын дотроос ч олон хүн хувь хувиар цэцэг тавилаа, Цэцгийг ойр орчмын уул модноос түүж ирсэн тул янз бүрийн хурц өнгө эрээлжлэн алаглаад анхилам сайхан үнэр нь хэвээр ханхалж байв. Пионерын бүрээ бөмбөр ч эгшиглэн байв. Олон хүн энд тэндгүй зураг дарж байв. Нээлтийн эцэст ёохор бүжиг бүжиглээд тарав. Ёохор энд анх үзэхэд XII—XI зууны монголчуудын дэвсэн бүжих бүжигтэй адил

төстэй бөгөөд тухайн үеийн байдлыг санагдуулж байв. Тэнгэр цэлмэг намуун маш сайхан байв. Хүмүүсийн сэтгэл ханасан байдалтай баясгалан цэнгэл нүүр бүр дээр үзэгдэж байв. Гагцхүү уг нээлтийг улам өргөн хэмжээгээр төвийн дээд байгууллагаас эрхлэн гүйцэтгэж кино зураг авсан болоосой гэж хүсэл санаа хүмүүсийн амнаас цухалзаж байв.

Хөшөөг нээсний дараа Дадал сумын наадам болов. Биднийг цөмийг урьж аваачин гол асарт аймгийн даргын дэргэд суулгав. Бөх барилдаж морь уралдав. Дорнодын бөх Чанрав заан түрүүлж Доржсүрэн начин үзүүр булаалдав. Чингисийн эр хоёр загалын төрсөн нутаг Сант Хайрханы халтар морь түрүүлэв. Тэр өдөр туж найр наадам болж байгаад орой тийш тарав. Уг нь хөдөлмөрчдийн зохистой нэг ажил амжилттай дууссаны баяр гэж байсан. Үнэхээр Чингисийн Хөшөө нээхэд зориулж нутгийн олон морь сойх зэрэг их бэлтгэл хийгээд байсныг харгалзан тэгсэн биз. Гэвч уг наадам үнэн хэрэг дээрээ Чингисийн хөшөөг нээсний баяр болсон юм.

Орой 7 цаг хагаст аймгийн дарга Адъяа, сум, нэгдлийн дарга, намын хорооны нарийн бичгийн дарга, Онон амралтын дарга, зураач Махбал, инженер Чойжамц нар цугларч Чингисийн хөшөөг хүлээн авч, Дадал сумын захиргаанд шилжүүлэн хадгалуулах актанд гарын үсэг зураад оройн хоолыг цайллагын журмаар архи дарстай ууж идэцгээв. Цайллага дээр цөм нэлээд халж дотно сайхан ярилцаж байгаад тарав.

7-р сарын 4-нд Гурван нуурын өмнө орших Нүдний нуур гэдэг дээр очиж үзэв. Энэ нуур тунгалаг бөгөөд нүд угаахад үнэхээр сайн болдог ажээ. Тэндэхийн эмч нь нүд өвдсөн хүнийг тийш явуулдаг юм байна. Нүдний нуурын хуучин нэр нь Тогоот гэнэ. Нуурын зүүн хойт талд хөмрөөстэй том тогооны ёроол цухуйж байдаг байсан, тийм учир Тогоо нуур гэдэг байсан гэнэ.

Бид бас амралтын хойно орших Дэлүүн болдогийн эрээн толгой гэдэг дээр гарч үзэв. Тэр толгойн орой дээр хадаг яндар болсон нэлээд том овоо байна. Урьд бүүр ч том байсан бөгөөд жил бүр тахигддаг байжээ. Одоо ч гэсэн сүсэг бишрэл бүхий хүмүүс хадаг мөнгө тавьж тахиж тайж байдаг бололтой. Нутгийн захиргааны хариуцлагатай хүмүүс овооны хадаг яндар, мод чулууг хэд хэдэн удаа нураан хаяж шүтлэгийг эцэс болгох гэсэн боловч овоог дахин дахин сэргээн босгож байдаг хүмүүс бас байдаг юм байна.

Чухам энэ Эрээн толгойн хавийг Чингисийн төрсөн Дэлүүн болдог мөн гэж нутгийн ууган иргэд ярьдаг байсныг одоо мөн буриад нар уламжлан авч хүүрнэн ярьсаар байна.

Эрээн толгой дээрээс зүүн хойш дурангаар харвал Балжийн голын цаад талд уулын бэлд хоёр том хүрэн чулуу үзэгдэнэ. Түүнийг Чингисийн тамганы чулуу гэж ярьдаг гэнэ. Нутгийн ярианд тэр хад Чингисийг төрөхөд бүтэн байсан боловч Монголын төр байгуулагдмагц дундуур хагарч дотроос Чингисийн тамга гарсан гэдэг юм байна. Уг санаа Чингисийг төр байгуулахад тамга нь Монгол нутгийн чулуунаас гарсан гэх юм уу эсхүл Чингис хаан Монголын тулгар төрийг байгуулахдаа тамгын чулууг тэр хадны дотроос гаргаж авсан гэсэн үг юм.

Ер нь энэ нутгийн уул ус бүхэн сонин хачин домогтой юм. Онон голын тухай ярихдаа Тэнгэрийн хаан Хэрлэн, Онон, Туул гэдэг гурван сайхан охинтой байжээ. Их охин нь Хэрлэн, бага охин нь Туул юм, Онон гол дунд охин нь мөн бөгөөд харь нутгийн баатар эрд дурлаж хамгийн алс явах болсон тул түүнийг хамгийн сайхан хувцаслах хэрэгтэй болсон байна. Тийм учир Онон голын үзэсгэлэн бусдаас онцгой гоёмсог байдаг. Ер нь Онон голыг Хатан Онон гэж ярьдаг юм гэжээ. Энэ мэтийн домог яриа олон байдаг боловч бид цаг давчуу явсан учир зөвхөн цөөн заримыг олж сонслоо. Бид гол төлөв Чингисийн холбогдолтой домог сонирхож бага зэрэг зүйл цуглуулсан тул түүнээ энэхүү тэмдэглэлийн ард хавсаргая.

7-р сарын 5-ны өглөө бид Улаанбаатарын зүг буцах болов. Амралтын дарга Осор гуай биднийг үдэж Дадал суман дээр хамт ирээд өөрийн нэгэн хамаатныд буулгаж Монгол нэрлийн архи уулгаж дайлав. Тэр айлын өрхийн толгойлогч нь Дондог гэдэг хижээл насны хар хүн байна. Эхнэр нь Нансалмаа гэдэг сайхан зантай авгай байна. Дондог, Нансалмаа нар биднийг ихэд хүндлэн үйлчилж монгол архи нэлээд уулгав. Бид нэлээд халамцаад гарав. Тэдэнтэй зураг авахуулж баяр талархал илэрхийлээд салахын ёслол гүйцэтгэж жин үдийн 12 цагт машиндаа сууж нутгийн зүг хөдлөв.

Удалгүй Хатан Ононд хүрэлцэн ирлээ. Машинаас бууж Онон голд нүүр гараа угааж сэрүүцээд харуузаар (пирваазаар) гарч одлоо.

Нэлээд холдсоны дараа Чингисийн төрсөн нутаг Ононгийн хөндий уулсын цаагуур далд орох шахав. Хоёр уулын хоорондуур далд орох гэж байгаа нь кино дуусч дэлгэцийн хөшиг хаагдаж байгаа мэт байв. Бид машинаа зогсоон бууж, Чингисийн төрсөн нутаг Хатан Ононы гоёмсог уул хөндийг сэтгэл бахдан ширтэж баахан зураг дарлаа. Зураач Махбал гар зураг хийж авлаа. Эндээс Ононы сав газрын үзэсгэлэн гойд сайхан харагданам. Наанаас очоод эндээс харахад яг л Чингисийн тухай кино эхлээд дэлгэцийн наад хөшөөг нээхдэн Хатан Ононы хавь орчмын домог үзэсгэлэн бүрдсэн уулсын бараа цэнхэрлэн хөхөртөж харагдах мэт байдаг, буцах замд эргэж харахад улам ч үзэсгэлэнтэй болоод нүд салган хагацаж одоход харамсах сэтгэл төрүүлнэ.

Бид замдаа сайн явж Өндөрхаан дээр ирж Адъяа гуайтай уулзаад гарлаа. Замдаа Хэрлэн голын гүүрийн дэргэд бууж усанд орж биеэ угааж сэрүүцэн амрав. 7-р сарын 6-ны орой 9 цаг хагаст Улаанбаатар хотдоо хүрэлцэн ирж гэртээ буув.

Ингэж Чингис хааны 800 жилийн ойг тохиолдуулан төрсөн нутаг Дэлүүн болдогт нь босгосон дурсгалын хөшөө хүлээн авах ажлын аян зам аятай сайхан дуусгавар болов.

7-р сарын 7-ны өглөө Академийн Дэд ерөнхийлөгч дээр орж, явсан ажлын тухай тодорхой ярьж илтгэн, хөшөө хүлээлцсэн актуудын хувийг гардуулж өгөв.

11 цагийн үед Түүхийнхээ хүрээлэн дээр ирж захирал Нацагдоржтой уулзаж уг явдлын тухай илтгэж яриад ажилдаа оров.